

Цогт Налэндагийн арван долоон их бандидагийн залбирал
Гурван сүжгийг тодруулагч

Амьтанд туслахыг зорисон нигүүлсэнгүйгээс машид мэндэлсэн
Авралын дээд тэвчил онолыг олсон тэнгэрийн тэнгэр
Шүтэн оршихуйн сургаалаар амьтдыг татан зохиосон
Чадагчийн эрхэт өгүүлэхүйн наранд оройгоороо мөргөө.

1. Бурханыг үүсгэгчийн утга хязгаараас хагацсан түүнийг
Шүтэн оршихуйн гүнзгий нотолгоогоор тодруулахдаа мэргэн
Бурханы эшилсэнчлэн дээд хөлгөний төвийн ёсыг
Сайтар нээгч Нагаржунайн өлмийд соёрхол өргөмүй.
2. Түүний ахмад шавь мэргэн бүтээлчийн дээд
Дотоод гадаадын номын далайн хязгаарт хүрсэн
Нагаржунайн номыг баригчидын оройн цогт эрдэнэ
Нигүүлсэнгүй бурханы хөвгүүн Арьяадэва-д соёрхол өргөмүй.
3. Хутагтын таалал шүтэн оршихуйн туйлын утга
Харгалзан орших, дан нэр төдий гүнзгий оньсыг
Тодруулан айлдагч дээд бүтээлчийн газарт заларсан
Буддабалидагийн өлмийн лянхуад соёрхол өргөмүй.
4. Үнэн бодьтой үүсэх тэргүүтний хязгаарыг няцааж,
Ухааны зохилдсон үзэгдэл гадны утгыг таалсан
Тогтсон тааллын журмыг нээгч төгс бандида
Тойн багш Бхававивека-д соёрхол өргөмүй.
5. Харгалзан шүтэх шалтгаан төдий энэ ямагтаар
Хоёр хязгаарыг арилгагч хоосон үзэгдэл төв ёс
Гүн дэлгэрийг увадислагч, судар тарнийн бүрэн замыг
Гийгүүлэн зохиогч Чандрагирди-д соёрхол өргөмүй.
6. Гайхамшигийн туйл болсон их нигүүлсэнгүйн зам
Гүн, агуу ихийг нэн олон ухаанаар
Сайн хувьт шавийн чуулганд номлохдоо мэргэн
Шантидэва бодьсатвагийн өлмийд соёрхол өргөмүй.
7. Шавийн сэтгэхүйчлэн хоёрыг үгүйсгэх төв мөр
Шалгагч, төв ухааны ёсыг нээхдээ мэргэн

Цастын оронд Ялгуусаны шашиныг дэлгэрүүлэн зохиогч
Цаглаш үгүй ачит Шантаракшита-д соёрхол өргөмүй.

8. Хязгаараас хагацсан төв үзэл ба амирлангуй үлэмж
Хосолсон бясалгалын зэргийг судар дандарын дагуу
Тайлбарлаад цастын орны Бурханы шашиныг эндүүрэлгүйгээр
Тодруулан зохиогч Гамалашилагийн өлмийд соёрхол өргөмүй.

9. Майдар дэгтрэн дэмжсэнээр их хөлгөний аймаг бүгдийг
Машид аривдуулахдаа мэргэн, агуу их мөрийг үзүүлэгч
Ялгуусаны эшилсэнчлэн тийн ухаантын их журмыг
Ялган нээгч Асангагийн өлмийд соёрхол өргөмүй.

10. Илт номын долоон аймаг, хоёрыг үгүйсгэгчийн ёсыг бариад
Утгыг өгүүлэгч, тийн ухаантын тогтсон тааллыг тодруулан зохиогч
Хоёрдугаар бүхнийг болгоогчид алдаршсан мэргэний дээд
Хосгүй багш Басубандугийн өлмийд соёрхол өргөмүй.

11. Бодит нотлохуйн ухаанаар Чадагчийн сургаалын утгыг
Батлахын тулд шалгадагийн зуун үүдийг сайтар нээгээд
Нэн шинжлэх оюуны нүдийг өгөгч шалгадаг ухаанч
Нигүүлсэнгүй Дигнага-ийн өлмийд соёрхол өргөмүй.

12. Шалгадагийн гадаад дотоодын аньс бүгдийг сайтар болгоож,
Судрын аймагтан, сэтгэл төдийтний гүн дэлгэр мөр бүхнийг
Нотолхуйн ухаанаар ойлгуулах гайхамшигт ёсыг увадислахдаа
Нэн мэргэн Дармагирдигийн өлмийд соёрхол өргөмүй.

13. Асанга ахан дүүсээс дамжсан билгүүнд хүргэгчийн утгыг
Буй үгүй хязгаараас хагацсан төвийн ёсны дагуу
Илт онохуйн чимгийн утгыг гийгүүлэх зулыг бадраасан
Арьяа Вимуктисенагийн өлмийд соёрхол өргөмүй.

14. Эх судрын утгыг нээх ялгуусаны бошигыг олсон
Үл дийлдэгч Итгэлийн увадис ямарчлангийн дагуу
Үлэмж чанадад хүргэгч гурван эхийн утгыг тодруулагч
Их багш Харибадрагийн өлмийд соёрхол өргөмүй.

15. Буман винайн аймгийн утгыг сайтар хураангуйлаад
Бүхнийг буйд өгүүлэгчийн ёсоор ангид гэтэлхүйг

Эндүүрэлгүй сайтар увадисласан бат мэргэний дээд
Амарлингуй Гунапрабхагийн өлмийд соёрхол өргөмүй.

16. Гурван суртгаалын эрдэм чандманы гууг эрхшээсэн
Гэм үгүй винайн шашиныг өнөд дэлгэрүүлэхийн тулд
Агуу их номын утгыг сайтар дэлгэсэн винайг баригчийн дээд
Амарлингуй Сахяпрабхагийн өлмийд соёрхол өргөмүй.

17. Чадагчийн айлдсан гүн дэлгэр зарлиг ёс бүгдийг
Гурван төрөлхтөний мөрд хураан увадислан зохиогоод
Цаст орны шашиныг дэгжээсэн ачит богд
Жову Атиша гэгээний өлмийд соёрхол өргөмүй.

Тийнхүү Замбуу тивийн чимэг, мэргэдийн туйл
Гайхамшигт сайн номлолын уурхай дээдэс нарт
Тунгалаг хувирашгүй сэтгэлээр соёрхол тавин залбирмуй
Бидний үндсийг боловсруулан гэтэлгэн адислан хайрла.

Оршихуйн суурь ёсон хоёр үнэнийг ухаарч
Орчлонд орох буцахыг дөрвөн үнэнээр магадлаж
Гурван авралд шалгагчаар татагдсан баттай сүжиг
Гэгээрлийн мөрийн ёзоорыг бататган адислан хайрла.

Зовлон бүхнийг нэн амарлиулсан гэгээрлийг чухалчилсан
Магад гарах оюун ба амьтныг аврахыг хүссэн
Зүгийн хязгаарт тулсан нигүүлсэнгүй сэтгэлийн ёзоорт
Засвар үгүй бодь сэтгэлийг төрүүлэн адислаж хайрла.

Их уламжлалыг нээгчдийн номын утгануудад
Сонсож, санан бясалгасанаар чанадад хүрэхүй хийгээд
Очирт хөлгөний гүн аньс мөр бүхэн дор
Амар хялбар магадлалыг олоход адислаж хайрла.

Эгнэгт төрөл дутамдаа гурван суртгаалт шүтээнийг
Эндүүрэлгүй сайтар олоод, номлол ба бүтээлээр
Эш онолын шашиныг барин, дэлгэрүүлэх үйлсийг
Их уламжлалыг нээгчидтэй ижилхэн бүтээх болтугай.

Хүрээ хийд бүхэнд сонсох санах номлох бүтээхийн
Хичээлээр цагийг өнгөрөөж, буруу амжиргааг огоот тэвчсэн

Дээдийн мэргэн бүтээлчид машид арвидсанаар
Дэлхийн уудам хөрсийг үргэлжид чимэх болтугай.

Үүгээр судар дандарын бүрэн замыг туулаад
Хоёр тусыг зөнгөөрөө бүтээх бүхнийг болгоогч
Үлэмж бурханы хутагыг үтэр түргэн олоод
Огторгуйг орштол амьтны тусыг үйлдэх болтугай.

Хэмээсэн үүнийг бичсэн учир нь:

Ялж төгс нөгчсөн бурханы сайтар номлосон гүн хийгээд агуу их номын ёс эдгээрт, дээр дурьдсан энэтхэг хутагтын орны мэргэдийн манлай тэдгээрүүд нэн шинжлэн судлагч нарын оюуны нүдийг сайтар нээгч гайхамшигт тайлбаруудыг зохион туурвиад хүмүүний 2550 шахам жил болжээ. Гэвч өнөөг хүртэл сонсох санах бясалгахын гол судлагдхуун хэвээр оршисоор байгаа тул мэргэдийн манлай тэдгээрийн зарлигийн ачийг эргэн санах, хувирашгүй сүжгээр тэдгээрийг дууриан суралцахыг хүсэж бичив. Мөн өнөөгийн дэлхий нийтэд шинжлэх ухаан болон техник технологийн өндөр хөгжилд хүрээд, энэ насны хуран үймээний тийн алгасралаар ихэд хямарсан энэ үед, бурханы шашинтан бид нар, бурханыхаа сургаальд мэдлэгт суурьлан сүжиглэх нь хамгаас илүү чухал тул шудрага оюунаар эргэцүүлэх үүднээс нягтлан шинжлэн судлаад, учир шалтгааныг нь тодруулах, учир шалтгааныг нь мэдээд билгүүн лүгээ нөхөрлөсөн сүжгийг төрүүлэхэд нийтэд алдаршисан зургаан чимэг хоёр дээд хийгээд Буддабалида болон Арьяа Вимуктисена тэргүүтний гүн дэлгэрийг үзүүлсэн гайхамшигт номлол эдгээр нь зайлшгүй хэрэгтэйг үзээд, зургаан чимэг хоёр дээдийн дүрүүдийг хамтатган бүтээдэг уламжлалт ёс урьдаас байсаны дээр гүн дэлгэрийн дамжлагын бусад есөн багш нарыг нэмээд, Налэндарын 17-н бүтээлч бандида нарын хөргийг шинээр бүтээх лүгээ хамтатган мэргэдийн оргил тэдгээрт зүрхнээсээ биширсэн энэхүү залбирлыг бичих хүсэл төрсөн хийгээд утгыг эрхэмлэгч зарим номын нөхдийн зүгээс ч сануулга гарсанд шүтээд, Цогт Налэндарын 17-н их бандида нарын залбирал “Гурван сүжгийг тодруулагч” хэмээх үүнийг мэргэдийн манлай тэдгээрийн сайтар номлолд засвар үгүй итгэмжилсэн сүжгийг олсон, тэдгээр мэргэдийн сайтар номлолд суралцагсдын суудлын захад багтсан, Шагжаан гэлэн Данзинжамц бээр Бат-Оршигчийн аймгийн ёсоор Бурхан багш Амгаланд заларсанаас хойш 2545 жил, түвдийн XVII жарны төмөр могой жилийн XI сарын шинийн нэгэн, гадны тооллын 2001 оны XII сарын 15-ны өдөр, энэтхэгийн Химачал аймгийн Ганра сумын харьяа, Дхарамсалагийн Их хөлгөний номын тивд бүтээн үйлдэв. Буян дэлгэрэх болтугай.